



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 589

Улаанбаатар хот

“Гэби фирм” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн бүтэц,
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэби фирм” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Гэби фирм” ХХК /Н.Мишэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН